



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/239

Хэрлэн сум

Зарим аж, ахуй нэгжийн үйл
ажиллагааг зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Сонгуулийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1, 96.1.1, 96.1.2, 96.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр болохтой холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр үйлчилгээ, спортын зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг 2017 оны 06 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвүүдийг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр үйл ажиллагаа явуулахыг тус тус түр зогсоосугай.

Хоёр. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/-д, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа /Ж.Болд/-д, сумдын Засаг дарга, тосгоны Захирагч нарт тус тус даалгасугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА